



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/125

Улаанбаатар хот

「 Газар эзэмших эрхийн талбайн хэмжээ, зориулалт, байршил, хаяг өөрчлөх, хамтран эзэмшигч нэмэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.1, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 182 тогтоол, Газрын харилцаа геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 10/09 тогтоол, дүүргийн “Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл”-ийн 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хурлын дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн талбайн хэмжээ, зориулалт, хаяг өөрчлөх, хамтран эзэмшигч нэмэх тухай ирүүлсэн 3 /гурав/ иргэн, аж ахуй нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад заасны дагуу өөрчилсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2018 оны А/526 дугаар захирамжийн 6, 7 дугаар заалтын Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газарт, дүүргийн Засаг даргын 2017 оны А/598 дугаар захирамжийн иргэн Н.Баасандамба нарт холбогдох хэсгийн газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжид холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гэрээ байгуулж, газрын улсын бүртгэлд бүртгэх, гэрчилгээ олгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын алба /Г.Мөнхбаатар/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА

1160200303

4. Газар эзэмших эрхийн талбайн хэмжээ, зориулалт, байршил, хягт өөрчлөх, хамтран эзэмшигч нэмэх тухай

Д/д	Газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Регистрийн дугаар	Газрын байршил /хороо/	Зориулалт	Хэмжээ /м2/	Хугацаа	Эдлэлбэрийн хэлбэр	Өмнөх эзэмшигч, зориулалт, талбайн хэмжээ, байршил, нэр	Өмнөх шийдвэр	Нэгж талбарын дугаар
1	Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар	9088822	20-р хороо, Үйлдвэрлэлийн баруун бүс-4 /16103/	Түлш хадгалах агуулах	4996	2033.10.25 хүртэл	Эзэмшүүлэх	Архивын барилга	2018 оны А/526	1681910101, Э-2205000008
2	Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар	9088822	20-р хороо, Үйлдвэрлэлийн баруун бүс-4 /16103/	Архивын барилга	4996	2033.10.25 хүртэл	Эзэмшүүлэх	Түлш хадгалах агуулах	2019 оны А/526	1681910102, Э-2205000007
3	Боржигин овогтой Ноовын Баасандамба, Боржигон овогтой Чойжоогийн Дуламсүрэн, Сартуул овогтой Шүрэнцацэгийн Чулуунцэцэг	ЧЛ79092817, ТВ78022547, СЛ77100207	20-р хороо, Үйлдвэрлэлийн баруун бүс-4 /16103/	Аж ахуй	3882	2032.12.18 хүртэл	Эзэмшүүлэх	Н.Баасандамба	2017 оны А/598	1681900009



Баянгол дүүргийн Засаг даргын Тамгаар  
 2019 оны 12-р сарын 12-ны өдрийн  
 Дугаар захирамжийн Хавсралт